



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**АГААРЫН НАВИГАЦИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
“МОНГОЛЫН АГААРЫН НАВИГАЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ,
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХЭСЭГ”**

**Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент
ажлын багийн анхдугаар хурлын тайлан**

Улаанбаатар хот
2019 оны 3-р сарын 11.

ГАРЧИГ

1. ТАНИЛЦУУЛГА
 - 1.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
 - 1.2. ЗОРИЛГО
 - 1.3. ХУРЛЫН БҮРЭЛДЭХҮҮН
2. ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
3. ТАНИЛЦУУЛГА, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
4. ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

1.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ОУИНБ-аас Ази-Номхон далайн бүс нутагт нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэхэд гишүүн улс орнуудыг чиглүүлэн ажиллаж байгаа билээ. Энэхүү ажлын хүрээнд 2010-2018 онуудад ATFM/CDM SG хурлуудыг 8 удаа зохион байгуулаад байна.

Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газраас санаачилсан Монголын агаарын навигацийн төлөвлөлт, хэрэгжилтийг хангах ажлын хэсэг (MANPING)-ийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн төлөвлөлт, хэрэгжилтийг хангах дэд ажлын хэсгийн анхдугаар хурлыг 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдөр ИНЕГ-ын хурлын танхимд амжилттай зохион байгууллаа.

1.2. ЗОРИЛГО

Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментэд оролцогч талуудад ерөнхий танилцуулга хийх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хэрэгжүүлэх хөтөлбөрийн төслийг танилцуулах, хэлэлцүүлэх

1.3. ХУРЛЫН БҮРЭЛДЭХҮҮН

Тус хуралд АНБЗГ, НХҮА, ЕЗНХА, НУТА, МТИСХА, “Эйр Чайна”, “МИАТ” ХК, “Аэромонголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК-ний нийт 30 гаруй төлөөлөгчид оролцов.





2. ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хуралдааны үйл ажиллагааг АНБЗГ-ын менежер П.Гантөгс нээж, Монголын агаарын навигацийн төлөвлөлт, хэрэгжилтийг хангах ажлын хэсэг (MANPING)-ийн зорилго болон түүний дэд ажлын хэсгүүдийн хурал амжилттай зохион байгуулагдаж байгааг дурьдан Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн ажлын багийн хурал нь ихээхэн ач холбогдолтойг цохон тэмдэглэж, хурлын төлөөлөгчдөд амжилт хүсэв.

Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент ажлын багийн хурлын хөтөлбөр

Даваа гараг	Үйл ажиллагаа	Агуулга
1000-1010	Нээлт	<ul style="list-style-type: none"> Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газрын дарга семинарыг нээж үг хэлнэ.
1010-1020	“Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент” ерөнхий танилцуулга	<ul style="list-style-type: none"> Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн ерөнхий танилцуулга хийнэ
1020-1030	“Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент хэрэгжүүлэх хөтөлбөр” төслийн танилцуулга	<ul style="list-style-type: none"> НУТМ-ийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн төслийн танилцуулга хийнэ.
1030-1040	Асуулт, хариулт	<ul style="list-style-type: none"> Танилцуулгын дагуу асуулт, хариулт
1040-1050	“Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент-Агаарын тээвэрлэгч” танилцуулга	<ul style="list-style-type: none"> НУТМ-ийн үйл ажиллагаанд агаарын тээвэрлэгчийн оролцоо, хэрэгцээ, шаардлагын тухай танилцуулга хийнэ.
1050-1100	Асуулт хариулт	<ul style="list-style-type: none"> Танилцуулгын дагуу асуулт, хариулт
1100-1110	“Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент-НХҮА” танилцуулга	<ul style="list-style-type: none"> НУТМ-ийн үйл ажиллагаанд Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын оролцоо, хэрэгцээ, шаардлагын тухай танилцуулга хийнэ.
1110-1120	Асуулт хариулт	<ul style="list-style-type: none"> Танилцуулгын дагуу асуулт, хариулт
1120-1150	Хэлэлцүүлэг	<ul style="list-style-type: none"> НУТМ-ийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөл, ажлын багын үйл ажиллагаанд хурлын төлөөлөгчдөөс санал, зөвлөмж авч, хэлэлцүүлэг хийнэ. Шийдвэрлэх асуудлуудыг хэлэлцэнэ
1150-1200	Дүгнэлт	<ul style="list-style-type: none"> Хурлын үр дүнг хэлэлцэнэ

Ажлын багийн танилцуулга

Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн талаар товч ойлголт, бүс нутаг, дэлхий нийтийн хэмжээнд хэрэгжиж буй байдал, Монгол улсад хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, нислэгийн төлөв, 2019-2028 оны хугацаанд 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх “EASY FLOW” хөтөлбөрийн төсөл зэргийг танилцуулан хэлэлцүүлэг хийлээ.

Танилцуулгын дагуу АНБЗГ, “МИАТ” ТӨХК, МТИСХА, Корэйн Эйр агаарын тээвэрлэгчдийн төлөөлөгчдөөс дараах санал, асуулт тавигдсан болно.

Үүнд:

- Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлснээр агаарын зайн хэрэглэгчдэд /агаарын тээвэрлэгчид/ нислэгийн төлөвлөлтийн мэдээлэл хэрхэн дамжуулах
- Нислэгийн урсгал төлөвлөлтийн тодорхойлолтыг албан ёсоор Монгол хэлэнд хөрвүүлэх
- Хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааг тогтоох, журам боловсруулах
- ОХУ болон БНХАУ-ын нислэгийн судалгаа, тоо баримтаар танилцуулга хийх
- Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн талаар ойлголт өгөх
- Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэхэд эхний ээлжинд гадаад хүчин зүйлээс үл хамаарах, дотооддоо хийж, гүйцэтгэх боломжтой ажлуудыг хийж гүйцэтгэх

зэрэг байлаа.



“Эйр Чайна” агаарын тээвэрлэгчийн танилцуулга

Монгол улсын агаарын зайд үйлдэгдэж буй нислэгийн төлөв, байдал, Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн хэрэгцээ шаардлагын талаар танилцуулга хийсэн байна. Тус агаарын тээвэрлэгчийн Европ чиглэсэн бүх нислэг Монгол Улсын агаарын зайгаар үйлдэгддэг бөгөөд энэхүү чиглэлд POLHO-SERNA, POLHO-DARNO чиглэлд нэмэлт нислэг үйлдэх боломжтой эсэхийг тодруулахыг хүссэн болно. Ажлын багийн зүгээс энэхүү асуудал нь хурлын үйл ажиллагаа, чиглэлээс хазайж байгаа тул албан ажлын уулзалтаар шийдвэрлэх боломжтой болохыг илэрхийлсэн байна.



Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны танилцуулга

НХУ болон дээд агаарын зайн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд тулгарч буй асуудлуудаар танилцуулан, хэлэлцүүлэг хийлээ. БНХАУ-ын зүгээс Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн арга хэрэгслүүдийг авч хэрэгжүүлж байгаа нь Дээд агаарын зайн нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээнд хүндрэл учруулж байгаа талаар танилцууллаа. Танилцуулгаар:

- Хугацаагаар болон нислэгийн цуваагаар 1-3 дугаар сард нийт 62 удаа:
 - 1 дүгээр сард -30
 - 2 дугаар сард -28
 - 3 дугаар сарын 4-ний байдлаар 4 удаагийн хязгаарлалт хийсэн байна.
- Агаарын тээвэрлэгчдээс ирүүлж буй нислэгийн төлөвлөгөө нь урт хугацааны төлөвлөлтөөр төлөвлөсөн нислэгийн төлөвлөгөөтэй зөрүүтэй байдаг. Агаарын замын өөрчлөлттэй холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагааг зохицуулах хэрэгцээ үүсч байна.

- Хөрш улсуудаас нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн арга хэрэглэн хязгаарлалт тогтоосон тохиолдолд агаарын хөлгийг зогсоолоос асаах тооцоот цаг олгох үйл ажиллагааг зохицуулах зэрэг асуудлууд дэвшүүлэн хэлэлцүүлээ.

Ажлын багийн зүгээс дээрх асуудлуудыг хөтөлбөрт тусган танилцуулах, нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах, хуралд оролцогч байгууллагуудад “EASY FLOW” хөтөлбөрийн төслийг хүргүүлэн санал авахад үйл ажиллагаанд оролцогч талууд идэвхитэй хамтарч ажиллана гэдэгт найдаж байгааг илэрхийлэв.



3. ТАНИЛЦУУЛГА, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хавсралт үзнэ үү.

4. ДҮГНЭЛТ

Хурал Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын байр суурь, тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга замуудыг хэлэлцсэн ач холбогдолтой боллоо. Мөн оролцогч байгууллагуудаас “EASY FLOW” хөтөлбөрийн төсөлд санал ирүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Түүнчлэн Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент ажлын багаас хоёрдугаар хурлын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор НУТМ-д оролцогч талуудын танилцуулга, хуралд хэлэлцэх асуудлуудыг урьдчилан хүлээн авч дэвшүүлсэн тодорхой асуудлуудыг шийдвэрлэх,хэлбэрээр зохион байгуулж, хурлын үйл ажиллагааг өргөжүүлэх саналтай байна.

Танилцсан:

Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент
ажлын багийн дарга

Ч.Одгэрэл

Тайлан гаргасан:

Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент
ажлын багийн нарийн бичгийн дарга:

Т.Батбаяр

2019 оны 3-р сарын 11.